



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/635

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1, Засгийн газрын 2016 оны 10, 2020 оны 152 дугаар тогтоол, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XIII хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан Мөрөн сум 13 дугаар баг “Дулааны станц” ТӨХК-ийн ар талд байршилтай 3061438 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай газар эзэмшүүлэх дуудлага худалдаанд ялсан иргэн Чавчин барга овгийн Гомбодоржийн Доржноров (ЖЭ73121170)-д үйлдвэрлэлийн барилга байгууламжийн газрын зориулалттай 1309м² газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн Гомбодоржийн Доржноров (ЖЭ73121170)-той газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ